



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар

8783

Ховд

Д.Ижилболорыг ажилд түр томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Угтах үйлчилгээ 7043-1111 төвийн оператороор Даваадоржийн Ижилболорыг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 3 сарын туршилтын хугацаагаар түр томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Д.Ижилболортой хөдөлмөрийн хугацаатай гэрээ байгуулж удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Б.Ганболд)-д үүрэг болгосугай.


4. Д.Ижилболорыг Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ”-ний ТҮ-4 дахь зэрэглэл буюу 638212 төгрөг (зургаан зуун гучин найман мянга хоёр зуун арван хоёр)-өөр цалинг тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРСҮХ



8400003 0402
Tush B/83 Ba

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны
өдрийн Б/83 дугаар тушаалын хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Б.Цагаанцэцэг (Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийн
ахлах мэргэжилтэн (менежер)

Гишүүд: Х.Болормаа (Засаг даргын Тамгын газрын нярав)

Нарийн бичиг: П.Мандухай (Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн)

-оОо-